



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

ГАРЫН АВЛАГА

2024 он



**ХҮН ХУДАЛДААЛАХ
ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ,
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА,
ТҮҮНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ**

ГАРЫН АВЛАГА

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

2024 ОН

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН
ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА,
ТҮҮНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ**

ГАРЫН АВЛАГА

Боловсруулсан:

Г.Золзаяа *УЕПГ-ын ХБМБАХТХ-ийн хяналтын прокурор*

Хянасан:

М.Чинбат *Улсын ерөнхий прокурорын орлогч*

О.Мөнхбаатар *УЕПГ-ын ХБМБАХТХ-ийн дарга*

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж-18
Улсын Ерөнхий прокурорын газар

Утас: (+976) 51-260855

Факс: Е-майл: gpo@prokuror.mn

АГУУЛГА

Нэг. Оршил	4
Хоёр. Олон улсын гэрээ конвенц,	6
Гурав. Эрх зүйн зохицуулалт.	9
Дөрөв. Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбар	15
Тав. Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт	21
5.1 Шалгагдсан гэмт хэргийн талаарх гомдол, хэргийн шийдвэрлэлт	21
5.2 Гэмт хэрэг үйлдэгдсэн орон нутаг, газар, цаг хугацаа	22
5.3 Гэмт хэрэг үйлдэгдсэн арга, хэлбэр	23
5.4 Хохирогч	24
5.5 Шүүх шийдвэрлэсэн хэрэг.	30
Зургаа. Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт	36
6.1.Хохирогчийг таньж тогтоох	36
6.2.Хууль ёсны төлөөлөгч оролцуулах.	37
6.3.Өмгөөлөгч оролцуулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх.	39
6.4.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, сэтгэгцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох.	40
6.5.Хохирол нөхөн төлүүлэх.	43
6.6.Хохирогч хамгаалал.	44
6.7.Хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээ.	46
6.8. Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа.	48
Долоо. Зургийн жагсаалт	52
Найм. Графикийн жагсаалт	52
Ес. Ашигласан материал	53
9.1.Хууль тогтоомж	53
9.2.Улсын дээд шүүхийн тогтоол	53
9.3. Олон улсын гэрээ, конвенц, протокол	53
9.4. Холбогдох журам	54
9.5. Судалгааны дүн	55
9.6. Бусад материал	55

НЭГ. ОРШИЛ

Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай бүрэн гүйцэд явуулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтыг хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, арга, хэлбэр, шалгаж шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл, хууль хэрэглээний практикийг судалж, холбогдох арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага бий болсон.

Мөн Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментаас жил бүр эрхлэн гаргадаг “Монгол Улс дахь Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай” тайланд, “Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Хятад, Өмнөд Солонгос, Турк болон Ази, Ойрхи Дорнодын бусад орнууд болон Америкийн Нэгдсэн Улс руу худалдаж байна. Албан ёсны эх сурвалжийн үзэж байгаагаар Монгол Улсын иргэд Турк Улсад визгүй зорчдог, шууд нислэгтэй, цар тахлын улмаас Хятадын хил хааснаар хүмүүсийн аялал, хөдөлгөөний чиглэл өөрчлөгдөн шилжсэнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Турк Улс яваандаа хүлээн авагч орох болох магадлал байна” гэж дурджээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шинжийг зөв тодорхойлох, хууль хэрэглээний нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор 2022-2023 оны байдлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 13.13 дугаар зүйл “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийг хамруулан, холбогдох шийдвэрт дүн шинжилгээ хийж, мөрдөн шалгах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт, хууль хэрэглээнд анхаарах асуудлын талаар гарын авлага боловсрууллаа.

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХЭРЭГ
БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ТАВИХ ХЭЛТЭС**

ХОЁР. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦ

2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, оролцогц улс хоорондын хамтынажиллагааг дэмжих зорилгоор “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-ыг баталж, Хүн худалдаалах гэмт хэргийг /зорилго, үйлдэл, арга/ гурван элементийн нэгдэлд тодорхойлсон байна.

Зорилго	Үйлдлийн арга	Үйлдэл
Мөлжлөг: 1. Бэлгийн мөлжлөг, 2. Биеийг үнэлүүлэх, 3. Албадан хөдөлмөр, үйлчилгээ, 4. Боолчлол, 5. Түүнтэй төстэй үйл ажиллагаа, 6. Эд эрхтнийг нь авах	1. Төлбөр төлөх, 2. Төлбөр хүлээн авах, 3. Давуу байдал бий болгох 4. Эмзэг байдлыг нь ашиглах, 5. Эрх мэдлээ урвуулан ашиглах, 6. Хууран мэхлэх, 7. Залилан мэхлэх, 8. Хулгайлах, 9. Бусад хэлбэрээр албадах, 10. Хүч хэрэглэх, 11. Хүч хэрэглэхээр заналхийлэх	1. Элсүүлэх, 2. Тээвэрлэх, 3. Шилжүүлэх, 4. Орогнуулах, 5. Хүлээн авах

Протоколын 3 дугаар зүйлд, “Хүн худалдаалах” гэж “хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдэл”-ийг хэлнэ;

“Мөлжих” гэж “бусдын биеийг үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно” гэж тодорхойлсон. Мөн мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэж заажээ.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдөр баталж, 2002 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон Хүүхдийн конвенцийн нэмэлт болох “Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол”-д хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах зорилгоор олон улсын хэмжээнд хууль бусаар хил зувчуулан тээвэрлэх явдал мэдэгдэхүйц нэмэгдсэн, хүүхдэд аюултай секс аялал

өргөжин үргэлжилж, ялангуяа энэ нь хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахад шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд бэлгийн хүчирхийллийн дийлэнх хувийг бага насны охид эзэлж байгаа, интернэт болон бусад дэвшилтэд технологийн хүчээр хүүхдийг садар самуунд сурталчлах явдал нэмэгдэж байгаа зэргийг гол үндэслэл болгосон байна.

Протоколд оролцогч улсууд өөрийн хуульдаа хүүхдийг аливаа арга хэрэгслээр санал болгох, шилжүүлэх буюу авах, хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж, хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх үйлдэл, үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцон, уг гэмт хэрэг нь улсын дотоодод болон үндэстэн дамнасан, ганцаарчилсан болон зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэн байхаас үл хамааран хариуцлага хүлээлгэх талаар дурдсан байна.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол” /Палермогийн протокол/-д Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон.

Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод хүлээсэн үүргээ биелүүлэн, Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэл, эс үйлдэхүйн шинжийг тодорхойлсон байдаг.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (1996)¹

1996 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тухайн үед хүчин төгөлдөр дагаж мөрдөж байсан 1986 оны Эрүүгийн хуулийн “Хүний хувийн эрх чөлөөнд халдсан гэмт хэрэг” бүлгийн 111 дүгээр зүйлд “Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх” гэж хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан.

111 дүгээр зүйл. Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх

1. Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

¹ Шүүхийн академиас хийсэн “Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгаа”-ны тайлан”-д

2. Энэ гэмт хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлсэн буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хууль (2002)

2002 оны Эрүүгийн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд нэр төрийн эсрэг гэмт хэрэг” бүлгийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” хэмээн томьёолж хүн худалдаалахыг бие даасан гэмт хэрэг байхаар хуульчилжээ. Үүнд:

113 дугаар зүйл. Хүн худалдах, худалдан авах

113.1. Хүн худалдсан буюу худалдан авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Энэ хэргийг:

113.2.1. хүний цус, эд, эрхтнийг ашиглах зорилгоор;

113.2.2. биеийг нь үнэлүүлэх зорилгоор;

113.2.3. давтан;

113.2.4. хоёр буюу түүнээс олон хүнийг;

113.2.5. насанд хүрээгүй хүнийг;

113.2.6 бүлэглэж буюу урьдчилсан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.3. Энэ гэмт хэргийг байнга үйлдсэн, хүнийг хил давуулан худалдсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2012)

2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг баталж, эрүүгийн хуулийн холбогдох заалтад дахин нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012) 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1."хүн худалдаалах" гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг;	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2012) 1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 113 дугаар зүйл. Хүн худалдаалах 113.1.Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхцийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан бол эд хөрөнгийг хурааж, гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
--	---

Эрүүгийн хууль (2015)

2015 оны Эрүүгийн хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хүн худалдаалах гэмт хэрэг болон бэлгийн мөлжлөг гэмт хэргүүдэд тодорхой өөрчлөлтүүд орсон байна. Хүн худалдаалах гэмт хэргийн шинжид протоколын 3 дугаар зүйлд заасан мөлжих зорилго, үйлдэл, арга гэсэн 3 шинжийг багтаасан байна.

Харин Эрүүгийн хуульд гэмт хэргийн шинжийг тодорхойлохдоо, протоколд заасан шинжийг хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөг гэж тусад нь зааглан, гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрлийн хэмжээг хэт зөрүүтэй байдлаар хуульчилсан нь хууль хэрэглээний практикт эргэлзээтэй байдлыг үүсгэж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд “биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол” хүн худалдаалах гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.

Гэмт хэргийн шинжид гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирогчийн биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох,

түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжиж ашиг олох зорилгоор эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, бусдад дамжуулсан, бусдаас хүлээн авсан байх, уг үйлдлээ хэрэгжүүлэхдээ хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлөх, хахуульдах арга ашигласан байхыг шаардаж байна.

Түүнчлэн хүнийг мөлжих зорилгоор хуульд заасан аргуудыг ашиглаж, нэг байрлалаас нөгөөд шилжүүлснийг хохирогчийн зорчих эрхийг хязгаарласанд тооцож, энэ гэмт хэргийн шинжийг хангасан гэж үзнэ.

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд “хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр, бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол” бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ. Гэмт хэргийн шинжид гэмт этгээд нь ашиг олох зорилгоор хохирогчийн зорчих эрхийг нь хязгаарлахгүйгээр бусадтай албадан бэлгийн харьцаанд оруулсан байх, уг үйлдлээ хэрэгжүүлэхдээ хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулсан байхыг шаардаж байна.

Үүнээс үзвэл, бэлгийн мөлжлөг гэмт хэрэг нь хүн худалдаалах гэмт хэргээс хохирогчийн халдашгүй, чөлөөтэй байх эрх, бусадтай харилцах, өөрийн хүслээр

зорчих эрхийг нь хязгаарладаггүй, эрх чөлөөтэй байдалд нь бүрэн хяналт тогтоодоггүй шинжээр ялгагдаж байна.

Тухайлбал, Улсын дээд шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2-т зааснаар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулж шийдвэрлэсэн 1 хэргийг хянан хэлэлцээд, зүйлчлэлийг мөн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан, бэлгийн мөлжлөг гэмт хэргээр хөнгөрүүлэн өөрчилж шийдвэрлэсэн. Тогтоолд, "...Хүн худалдаалах гэмт хэрэгт зарим талаараа нийцэх бэлгийн мөлжлөгийн шинжтэй үйлдлийг хууль тогтоогч бие даасан гэмт хэрэгт тооцож, хохирогчийн халдашгүй, чөлөөтэй байх эрх, өөрийн хүслээр зорчих, бусадтай харилцах эрх чөлөөнд хяналт, хязгаарлалт тогтоосон шинжгүй байхаар хуульчилсан тул эдгээр гэмт хэргүүдийн ижил төстэй болон ялгаатай шинжүүдийг зөв тодорхойлж, хэргийн зүйлчлэлийг тогтоох нь шүүхээс хууль ёсны, үндэслэлтэй шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой юм." гэж дурджээ. (УДШ 2023.03.31 №65)

ДӨРӨВ.**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ, ТАЙЛБАР**

Дээрх нэмэлт өөрчлөлттэй холбогдуулж Улсын дээд шүүх 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” 12 дугаар тогтоолоор хүн худалдаалах гэмт хэргийн зарим нэр томьёо (I) болон өрсөлдөх хэм хэмжээнээс ялгах шинжийг (II) тайлбарласан байна. Үүнд:

(I) Хүн худалдаалах гэмт хэргийн зарим нэр томьёоны тайлбар.п

“Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно,

“Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ,

“Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн” гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно,

“Хууран мэхэлсэн” гэж үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ. Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ,

“Эмзэг байдлыг нь далимдуулсан” гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно,

“Элсүүлсэн” гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна,

“Тээвэрлэсэн” гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно,

Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.

“Дамжуулсан” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ,

“Орогнуулсан” гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд

шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно,

“Хүлээн авсан” гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно,

“Эрхмэдлээ урвууланашиглах” гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ,

“Эрхшээлдээ байгаа” гэдэгт эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно.

“Хил давуулан” гэдэгт хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар, эсхүл хуурамч буюу хууль ёсоор олж авсан баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна,

Хүнийг хил давуулан худалдаалахдаа хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ,

“Хүнд хор уршиг учирсан” гэдэгт хүнийг худалдаалахтай шууд холбоотойгоор амь нас нь хохирсон, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно,

“Биеийг нь үнэлүүлэх” гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ,

“Бэлгийн хүчирхийлэлд оруулах” гэдэгт биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно. Өрийн дарамтад оруулах зэргээр биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна,

“Албадан хөдөлмөр хийлгэх” гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ,

“Боолчлох” гэдэгт эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно,

“Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах” гэж хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ,

“Эд эрхтнийг нь авч ашиглах” гэдэгт хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ гэж тус тус тодорхойлжээ.

Түүнчлэн тус тайлбараар хүн худалдаалах гэмт хэрэг нь биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялгагдах шинжийг тайлбарласан байна.

Мөн “Палермогийн протокол”-ын 3 дугаар зүйлд, мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, нуун далдалсан буюу хүлээж авсан үйлдэл нь протоколд заасан, хүн худалдаалах болон мөлжих аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцохоор зааж, 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэдэгт хамааруулан ойлгох талаар тайлбарласан.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт: “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” буюу хүүхдийн биеийг үнэлүүлсэн, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулсан, боолчилсон, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгасан, хүүхдийн эд, эрхтнийг авсан, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Хүүхэд буюу 18 насанд хүрээгүй хүний хувьд, өөрийн үйлдлийн нийгмийн учир холбогдол, түүнээс гарах үр дагавар, хохирол, хор уршгийг бүрэн ойлгож ухамсарлах чадвар, чадамж бүрэн хөгжөөгүй, бусадтай харилцах харилцаа болон аливаа зүйлд бодитой дүгнэлт хийх, шийдвэр гаргах чадвар сул, сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшлийг олоогүй байдаг. Өөрөөр хэлбэл, өөрийгөө бусдын эрхшээлд орж, гэмт хэргийн хохирогч болж байна

гэдгээ ухамсарлан ойлгох, бодитой дүгнэлт хийх бүрэн чадваргүй гэж ойлгож болно.

Энэ төрлийн гэмт хэргийн учруулж болох хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг харгалзан, гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон тохиолдлыг онцгойлон авч үзэж, хуульд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр “Бэлгийн мөлжлөг”-ийн гэмт хэргээр бус “Хүн худалдаалах” гэмт хэргээр зүйлчлэн, мөрдөн шалгах ажиллагааг явуулж, нотолбол зохих байдлыг бүрэн шалгаж тогтоон, шийдвэрлүүлж байх нь зүйтэй байна.


ТАВ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ.

5.1 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэргийн шийдвэрлэлт.

Цагдаагийн байгууллага нь 2022-2023 оны байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн талаарх 42 гомдол, мэдээллийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. Гомдол, мэдээлэл гаргасан хүнээр авч үзвэл,


График-1.



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах”, 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 13.13 дугаар зүйлд заасан “Албадан хөдөлмөрлүүлэх” нийт 47 хэрэг шалгагдсан байна.

Графикаар харуулав.


График-2.



Судалгаанд хамрагдсан 47 хэргийн 40 буюу 88.1 хувь нь тухайн онуудад шинээр бүртгэгдэн шалгагдсан хэргүүд байна.

Шинээр бүртгэгдэн шалгагдсан хэргийг он тус бүрээр харьцуулан графикаар харуулав.

График-3.



5.2 Гэмт хэрэг үйлдэгдсэн орон нутаг, газар, цаг хугацаа

Шинээр бүртгэгдэн шалгагдсан 40 хэргийн 1 буюу 2.5 хувь нь орон нутагт үйлдэгдсэн бол, 39 буюу 97.5 нь Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна. Тухайлбал: Орон нутагт үйлдэгдсэн 1 хэрэг нь олон нийтийн үйлчилгээ явуулдаг газар болох зочид буудалд хоногоор биеэ үнэлсэн.

Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн хэргүүдийн 18 буюу 46.2 хувь нь зочид буудалд, 3 буюу 7.7 хувь нь түрээсийн орон сууц, тусгайлан бэлтгэсэн орон байр, ажлын байранд, 18 буюу 46.2 хувь нь өөрийн, эсхүл үйлчлүүлэгчийн гэрт, автомашинд гэх мэтчилэн бусад газарт үйлдэгджээ.

Шинээр бүртгэгдэн шалгагдсан 40 хэргийн 3 буюу 7.5 хувийг Монгол улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн байна.

5.3 Гэмт хэрэг үйлдэгдсэн арга, хэлбэр

Шалгагдсан 40 хэргийг мөлжлөгийн хэлбэрээр авч үзвэл, 1 буюу 2.5 хувь нь хөдөлмөрийн мөлжлөг, 39 буюу 97.5 хувь нь бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр үйлдэгдсэн.

Үүнээс 22 буюу 55 хувь нь хохирогчийн гар утас, бусад харилцаа холбооны хэрэгслийг хураан авах, фэйсбүүк, инстаграммд нэтрэх нууц үгийг өөрчлөх, мессенжер, вайбер зэрэг цахим хэрэглээг нь хянах, өөрийн гэр, орон сууц, дэн буудал, түрээсийн болон нийтийн байрандаа аваачиж байрлуулах, өөрийн мэдлийн автомашинаар харгалзан хүргэх, хүлээж байгаад авч тээвэрлэх зэргээр зорчих эрхийг нь хязгаарлах, “...амь насанд нь халдана, бие эрхтнийг нь гэмтээнэ, цагдаагийн байгууллагад мэдэгдэж бүртгэлд оруулна, олон нийтийн сүлжээнд биеэ үнэлэгч гэж нийтлэнэ, ар гэрийнхэнд чинь байгаа байдлыг хэлнэ” гэх зэргээр айлган сүрдүүлэх, дарамтлах;

18 буюу 45 хувь нь “...бусадтай бэлгийн харьцаанд орвол мөнгө их олно, хурдан мөнгөтэй болно, олсон ашгаа хувь тэнцүү хувааж авъя, ихэнх ашгийг чамд өгнө” гэх мэтээр ятгах, их хэмжээний ашиг, орлого амлах зэргээр хуурах, санхүүгийн болон орон байрандаа байлгах зэргээр дэмжлэг үзүүлж, **үйл ажиллагаандаа элсүүлэх, улмаар** эрхшээлдээ бүрэн оруулах хэлбэрээр үйлдэгдсэн байна.

5.4 Хохирогчийн байдал

47 гэмт хэргийн улмаас нийт 98 хүн хохирсон бөгөөд бүгд Монгол Улсын иргэд байна. Үүнээс 87 буюу 89 хувийг нь мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчийн тогтоолоор хохирогчоор тогтоосон. Нийт хохирогчдын 6 нь эрэгтэй, 92 нь эмэгтэй, тэдгээрийн 46 нь насанд хүрсэн хүн, 52 нь хүүхэд байна.

Зураг 1. Хохирогчийн хүйс.







График 4. Хохирогчийн нас.



Гэмт хэргийн улмаас хохирсон 98 хүний 13 нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 84 нь 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах”, 1 нь 13.13 дугаар зүйлд заасан “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийн улмаас тус тус хохирсон байна.

График 5.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчөөс нийт 98 хохирогчийн 59-д нь гэмтлийн зэрэг тогтоох болон бэлгийн харьцаанд орсон ул мөр байгаа эсэхийг тогтоолгох, 39-д нь сэтгэцийн байдалд шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

График 6. Эзлэх хувь.

Насанд хүрсэн хохирогчдын хувьд өөрийн хүслээр амар хялбар аргаар мөнгө олох гэсэн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн гэмт хэргийн хохирогч болж байгаа байдал нийтлэг байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь гэмт этгээдийн дарамт шахалт, заналхийлэл, айлган сүрдүүлэлтээс үүдэлтэйгээр аливаа хэлбэрээр сэтгэл зүйн гэмтэл авах, бие махбодод нь гэмтэл учрах эрсдэл өндөр байдаг байна.

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа шинэчлэн батлагдсан Шүүх шинжилгээний тухай хуулийн 39.1 дүгээр зүйлд сэтгэцийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлагыг зааж өгсөн. Мөн зүйлийн 8 дахь хэсэгт “сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоохүнэлгээ”-г тогтоох зорилгоор сэтгэцийн шинжилгээг хийлгэх, 40 дүгээр зүйлд “Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг (Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг), Арван гуравдугаар бүлэг (Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг), 14.1 дүгээр зүйл (Ялгаварлан гадуурхах), ...Арван зургаадугаар бүлэг (Хүүхдийн эсрэг) ...зэрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахаар заасан.

Сэтгэцийн байдалд дүгнэлт гаргуулсан 39 хохирогчийн 10 буюу 25.6 хувьд нь сэтгэцэд учирсан гэмтлийн зэрэглэлийг тогтоолгохоор шинжээч томилж дүгнэлт гаргуулсны 9 буюу 90 хувь нь насанд хүрээгүй хүүхдүүд байгаад бүгдэд “хор уршиг 3 дугаар зэрэглэл”-д байгааг тогтоожээ.

Дээрх тоо баримтаас үзвэл, хохирогчийн сэтгэцэд учирсан гэмтлийг тогтоолгох ажиллагаа хангалтгүй байгаа нь харагдаж байх ба цаашид мөрдөгч, прокурор дээрх хуулийн зохицуулалтад нийцүүлэн холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулан, нотлох баримтуудыг цуглуулж, шинжээч томилон сэтгэцийн шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулж, хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгох, цаашилбал сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл

заслын эмчилгээнд зарцуулах зардлыг тогтоосон нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагааны явцад заавал хийлгэж хэвших шаардлагатай байна.

Хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад болон прокурорын хяналтын шатанд энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг мөнгөн илэрхийллээр тогтоож, хохирогчид нөхөн төлүүлсэн тохиолдол байхгүй.

Харин шүүхийн шатанд хэргийг хянан шийдвэрлэх явцад 5 хэргийн 6 шүүгдэгчээс нийт 3.989.068 төгрөгийг гаргуулж, хохирогч нарт олгуулахаар, мөн шүүгдэгч нараас 4.576.439 төгрөгийг гаргуулж, насанд хүрээгүй хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлсэн “Талита Ази Төв” ТББ-д олгуулахаар тус тус шийдвэрлэсэн.

Түүнчлэн 1 хэргийн 1 шүүгдэгч нь шүүхийн шатанд хэргийг хянан шийдвэрлэх явцад насанд хүрээгүй хохирогчид учруулсан 1.500.000 төгрөгийн хохирол, мөн насанд хүрээгүй хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлсэн “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-д үйлчилгээ үзүүлсний төлбөрт 2.440.808 төгрөгийг тус тус төлсөн талаар шийтгэх тогтоолд дурдсан байна.

Мөн 4 хэргийн 8 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж, хууль бусаар олсон орлого болох нийт 73.251.200 төгрөг, 1 хэргийн 4 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэхэд ашигласан 3 автомашины үнэ болох нийт 19.000.000 төгрөгийг хувь тэнцүүлэн гаргуулж, улсын орлого болгохоор шийтгэх тогтоолд дурдаж шийдвэрлэжээ. Тухайлбал:

1. Шүүхээс шүүгдэгч М-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар “хохирогчийг хүүхэд гэдгийг мэдсээр байж, эмзэг байдлыг нь далимдуулан биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулж хүн худалдаалсан” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, шийтгэх тогтоолд шүүгдэгч М-ээс насанд хүрээгүй хохирогч М-д 1.500.000 төгрөг, “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-д 2.440.808 төгрөг төлсөн болохыг дурдаж шийдвэрлэсэн. Мөн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хохирогчид учирсан гэм хортой холбоотой цаашид гарах зардлаа нотлох баримтаа бүрдүүлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүгдэгчээс нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч М-ээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 2.700.000 төгрөгийг гаргуулж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн.

(Мөрдөн шалгах ажиллагаагаар шүүгдэгч М-г гэмт хэрэг үйлдэж буюу насанд хүрээгүй хохирогчийг биеийг нь үнэлүүлж, худалдаалж өөрийн харилцах дансаар 2.700.000 төгрөгийг шилжүүлж авсан болохыг түүний эзэмшлийн дансанд үзлэг хийж, нотлох баримтаар бэхжүүлэн, гэмт хэргийн улмаас олсон орлого болохыг тогтоосон байх бөгөөд тус нотлох баримтыг үндэслэн шүүх хэрэг үйлдэж олсон орлогыг гаргуулж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна)

2. Шүүхээс шүүгдэгч П-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар “Арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэхээр заналхийлж, эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, шүүгдэгч П-ээс хүүхдийн мөнгөн тэтгэмж болох 900.000 төгрөгийг гаргуулж, насанд хүрээгүй хохирогч Б-д олгуулахаар, 4.576.439 төгрөгийг гаргуулж “Талита Ази Төв” ТББ-д олгуулахаар шийдвэрлэсэн.

Мөн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь насанд хүрээгүй хохирогчид учирсан гэм хорын хохирлын талаарх нотлох баримтыг хуульд заасны дагуу бүрдүүлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэм буруутай этгээдээс жич нэхэмжлэх эрхтэй талаар шийтгэх тогтоолд дурдаж тус тус шийдвэрлэсэн байна.

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ дээрх хуулийн зохицуулалтыг хэрэглэж байгаа бөгөөд хохирогч өөрт учирсан гэм хорын хохирлын талаарх нотлох баримтыг хуульд заасны дагуу бүрдүүлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэм буруутай этгээдээс нэхэмжлэх эрхийг нь нээлттэй зааж шийдвэрлэжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогч нар нь эрх зүйн бүрэн чадамжгүй, эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналт сул, анхаарал муу байдлаас шалтгаалан гэмт этгээдийн арга, заль мэхэнд автаж хууртагдах, тэдний заналхийлэлд өртөж, дарамт, эрхшээлд нь орж, гэмт хэргийн золиос болж байгаа мөн насанд хүрсэн хохирогч эмэгтэйчүүдийн хувьд хэдий насанд хүрсэн боловч амьдралын боломж тааруу, санхүүгийн хувьд хязгаарлагдмал, тодорхой эзэмшсэн мэргэжилгүй, ажилгүй байдлаасаа шалтгаалан амар хялбар аргаар их хэмжээний мөнгө олж, санхүүгийн асуудлаа түргэн шийдвэрлэх гэсэн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн бусдад хууртагдах, бусдын дарамт, заналхийлэл, сүрдүүлгэд өртөх байдлаар гэмт үйл ажиллагаанд нь элсэн орж, улмаар хохирч байгаа нөхцөл байдал тогтоогдсон байна.

5.5. Шүүх шийдвэрлэсэн хэрэг.

Прокуророос 29 яллагдагчид холбогдох 14 хэргийг шүүхэд шилжүүлснээс 10 хэргийн 20 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ.

График 7. Шүүхэд шилжүүлсэн хэргийн шийдвэрлэлт.



Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан 7 хэргээс 3-ыг нь “... хохирогч нарын чөлөөтэй зорчих эрх, бусад эрх чөлөөг хязгаарласан үйлдэл тогтоогдоогүй, хүн худалдаалах гэмт хэргийн шинжгүй” гэж дүгнэн, мөн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөг гэмт хэргээр хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэжээ.

Мөн хяналтын шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2-т зааснаар шийдвэрлэсэн 1 хэргийг хянан хэлэлцээд, “...шүүгдэгч нарын үйлдэлд нэр бүхий хохирогч нарын зорчих эрхийг хязгаарлаж, өөрсдийн болон бусдын эрхшээлд бүрэн оруулж, худалдаалах зорилгоор “элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан” гэж үзэх хууль зүйн үндэслэл тогтоогдоогүй”

гэж дүгнэн, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж, хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд зааснаар хөнгөрүүлжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан, хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчилж, яллах дүгнэлт үйлдсэн 7 хэргээс шүүх 4 буюу 57 хувьд нь зүйлчлэлийг өөрчилж шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

1. Т, Б нар нь насанд хүрээгүй Х,Э нарыг биеийг нь үнэлүүлж мөлжих зорилгоор эмзэг байдлыг нь далимдуулж, эмзэг байдлыг нь далимдуулж, эрхшээлдээ оруулан элсүүлэн тээврийн хэрэгслээр тээвэрлэн, орогнуулж, бусдад худалдаалсан” гэх эрүүгийн хэргийг Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь хэсэгт зааснаар шүүхэд шилжүүлснийг шүүх хянан хэлэлцээд, “...шүүгдэгч нарын үйлдэл Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн бүхий л шинжийг бүрэн агуулж байна. Өөрөөр хэлбэл “Хүн худалдаалах гэмт хэрэг нь эдгээр үйлдлүүдийн аль нэгийг нь хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг бөгөөд хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүй. Хохирогч худалдаалахыг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй. ...хуулийн тайлбарт “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй, хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь энэ гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй” гэж тус тус тайлбарласан байх ба тухайн гэмт хэргийн гарах болсон шалтгаан нөхцөл, сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэрийг зөв тогтоосон, зүйлчлэл тохирсон байна” гэж дүгнэн, шүүгдэгч Т, Б нарыг Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 6-7 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. **(БЗДЭХАШ 2022.10.12 ШЦТ №1472),**

2. М нь насанд хүрээгүй М-ийг биеийг нь үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт оруулан ашиг олох зорилгоор “амархан мөнгө олдог ажил хийе, мөнгөө тэнцүү хувааж авч байна, гар утсыг чинь солиод өгье, богино хугацаанд их мөнгөтэй болчихно” хэмээн хууран мэхэлж, ээжтэйгээ таарамжгүй байгаа эмзэг байдлыг нь далимдуулж, ятгах замаар элсүүлж, үргэлжилсэн үйлдлээр-ны өдрүүдэд биеийг нь үнэлүүлсэн буюу хүн худалдаалах гэмт хэргийг хүүхэд гэдгийг мэдсээр байж үйлдсэн гэж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан гэмт хэргээр зүйлчилж, шүүхэд шилжүүлснийг шүүхээс хянан хэлэлцээд, “...хүүхэд, эрүүл аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхийг нь баталгаатай эдлүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэгт “энэ гэмт хэргийг хүүхэд гэдгийг мэдсээр байж үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор хуульчилжээ.

“Эмзэг байдлыг нь далимдуулан” гэдэгт насанд хүрээгүй хохирогчийн хувьд эцэг эхийн анхаарал халамж сул, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал, хохирогчид үүссэн нэн чухал хэрэгцээ шаардлагыг ашиглан өөрт хамаарал бүхий болгох үйл явцыг авч үзнэ. Шүүгдэгч нь насанд хүрээгүй хохирогчийн гэр бүлийн анхаарал халамж сул, гэр бүлийн таагүй орчин эмзэг байдлыг нь далимдуулан хуурч, биеийг нь үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт оруулан ашиг олох зорилгоор нийтийн мэдээллийн сүлжээнд зар байршуулан, улмаар бэлгийн харьцаанд оруулж, банкны дансаар мөнгийг нь авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан хохирогчийг хүүхэд гэдгийг мэдсээр байж, эмзэг байдлыг нь далимдуулан биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулж, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн хангасан байна” гэж дүгнэн, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, 5 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн. Давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн. (ХҮДЭХАШШ 2023.02.03 ШЦТ №95)

3.П нь насанд хүрээгүй хохирогч Э-г биеийг нь үнэлүүлэх зорилгоор “чамайг биеэ үнэлэгч, эхнэртэй хүнтэй явалдсан гэж зургийг чинь фейсбүүкээр тараана, олон нийтийн сүлжээнд тавина” гэж айлган сүрдүүлж, хүч хэрэглэхээр заналхийлж, эмзэг байдлыг нь далимдуулж, насанд хүрээгүй хүүхэд гэдгийг мэдсээр байж, үргэлжилсэн үйлдлээр буюу ...-ны өдрүүдэд бусдад худалдаалсан,

Мөн насанд хүрээгүй хохирогч Х-г биеийг нь үнэлүүлэх зорилгоор “ээжийг чинь танина, наад хүнтэйгээ бэлгийн харьцаанд орохгүй бол ээжид чинь хэлнэ, хүмүүст хэлж од болгоход чи дуусна” хэмээн айлган сүрдүүлж, хүч хэрэглэхээр заналхийлж, эмзэг байдлыг нь далимдуулж, насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж, үргэлжилсэн үйлдлээр ...-ы өдрүүдэд бусдад худалдаалсан” гэмт хэрэг үйлдсэн гэж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан гэмт хэргээр зүйлчилж, шүүхэд шилжүүлснийг шүүхээс хянан хэлэлцээд, “...Хүн худалдаалсан гэдэг нь ашиг олох буюу мөлжих зорилгоор хүнийг мөнгө, эд хөрөнгөөр үнэлж өөр этгээдэд худалдахаар шилжүүлэн өгч, уг эд хөрөнгийг тохиролцсон ёсоор авсан байхыг ойлгоно. ...Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “биеийг нь үнэлүүлэх” гэдэгт хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулж, олсон орлогын тодорхой хэсгийг, эсхүл бүх орлогыг өөртөө авч, уг мөнгөөр өөрийн санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байсныг хэлэх бөгөөд шүүгдэгч П нь насанд хүрээгүй хохирогч нарыг бусадтай бэлгийн харьцаанд оруулсныхаа төлөө бусдаас төлбөр авч байсан болох нь тогтоогдож байна.

Эмзэг байдлыг нь далимдуулан гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно. ...Хүнийг худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

Мөн хохирогч нь өөрийг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар буюу хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж гэсэн аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй юм. Иймд шүүгдэгч П-г биеийг нь үнэлүүлэх зорилгоор, эмзэг байдлыг нь далимдуулж, хүч хэрэглэхээр заналхийлж, хүүхэд гэдгийг мэдсээр байж, хоёр хүнийг худалдаалсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 4 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн. (Өвөрхангай аймаг дахь сум дундын ЭХАШШ ШЦТ №75)

Мөн хүүхэд гэдгийг мэдсээр байж бусадтай албадан бэлгийн харьцаанд оруулсан илтэд Хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хангасан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан “бэлгийн мөлжлөг” гэмт хэргээр зүйлчилж, шүүхээр шийдвэрлүүлсэн тохиолдол гарсан байна.

Тухайлбал: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт: хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” буюу хүүхдийн биеийг үнэлүүлсэн, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулсан, боолчилсон, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгасан, хүүхдийн эд, эрхтнийг авсан, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байхад зөвхөн “хохирогчийн зорчих эрхийг хязгаарласан эсэх”-д дүгнэлт хийн шийдвэрлэсэн байна.

1.П нь иргэн Э-ийн эд хөрөнгийг авч захиран зарцуулах зорилго агуулж, өөрийн төрсөн охин насанд хүрээгүй Б-г хүч хэрэглэхээр заналхийлж, өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан түүний бэлгийн эрх чөлөөнд халдаж, Э-тэй хамтран амьдарч, бэлгийн харьцаанд орохыг шаардаж, бэлгийн харьцаанд албадан оруулсан” гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан гэмт хэргээр зүйлчилж, шүүхэд шилжүүлснийг шүүхээс хянан хэлэлцээд, “...Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах” гэмт хэргийн үндсэн шинжүүдийн нэг болох хохирогчийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулж байгаа үйлдлийг бэлгийн мөлжлөг гэж үзэхээр хуульчилжээ. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл буюу бэлгийн мөлжлөг нь мөн зүйлийн 1 дэх хэсэгт заасан диспозици шинжид “...зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол...” гэх шинжийг ялгаж зүйлчилсэн байна. Насанд хүрээгүй хохирогч П.Болорцэцэгт болон гэрчүүдийн мэдүүлэгт түүний зорчих эрхийг хязгаарлаж байсан талаар мэдүүлээгүй буюу зорчих эрхийг хязгаарлаж байсан талаар үйл баримт тогтоогдохгүй байна” иймд шүүгдэгч П-ийн үйлдлийг бэлгийн мөлжлөг гэж үзсэн нь үндэслэлтэй байна” гэж дүгнэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, 4 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн байна. **(БЗДЭХАШШ ШЦТ №160)**

ЗУРГАА. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

6.1 Хохирогчийг таньж тогтоох.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт “хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан, хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг ойлгохоор тодорхойлсон.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхийпрокурорын 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Журмын 2.1-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, сэжиглэгдэж буй этгээдийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан эсэхээс үл хамаарч хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хохирогчоор тогтооно” гэж, 2.2-т “Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд

хохилогчийг таньж тогтоох арга хэмжээг авна” гэж тус тус заасан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бусдад хууртагдсан, хүчинд автсан, бие болоод сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн, хохирсон, эмзэг, тусламж үйлчилгээ үзүүлэх нэн шаардлагатай байдгаараа бусад төрлийн гэмт хэргийн хохирогчоос ялгардаг бөгөөд хохирогчийг түргэн шуурхай таньж, тогтоох нь тэдний эрхийг хамгаалах эхний алхам болдог.

Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг хүлээн авсан даруйд хохирогчийг таньж тогтоох арга хэмжээг авч, хохирогчоор тогтоон, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлд заасан эрхээр хангаж буй эсэхийг хянан, энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасны дагуу мэдээллээр хангаж, хууль, журмыг нэг мөр хэрэгжүүлж ажиллах.


6.2 Хууль ёсны төлөөлөгч оролцуулах.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг, хэрэв дээрх хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан.

Судалгаанд хамрагдсан хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөг гэмт хэргийн улмаас 98 хүн хохирсоны 52 нь насанд хүрээгүй хохирогч байгаагийн дотор 17

буюу 32.7 хувьд тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг, 35 буюу 67.3 хувьд харьяа нутаг дэвсгэрийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнийг хууль ёсны төлөөлөгчөөр тус тус тогтоон оролцуулжээ.

График 8.



Эцэг эх, асран хамгаалагч-17

ГБХЗХГ-ын мэргэжилтэн-35

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдүүдийн 90 хувьд нь эцэг эхийн хараа хяналт сул, гэр бүлийн хүмүүжил муу зэргээс шалтгаалан гэрээсээ явсан, дайжсан, зугтсан, гэр бүлийн орчин, амьдралын нөхцөл байдалдаа гутарсан, эцэг эхээсээ холдсон, хөндийрсөн, тэдэнд хандаж асуудлаа ярих, тусламж дэмжлэг авахаас цааргалах, дургуйлхэх, өөрт тохиолдсон явдлыг мэдэгдэхгүй байх хандлагатай хүүхдүүд байгаа нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохгүй байх нөхцлийг бий болгож байна.

Мөрдөгч хуульд зааснаар зарим тохиолдолд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнийг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн улмаас

хүүхэд хохирсон тохиолдол бүрд насанд хүрээгүй хохирогчийн эцэг эх, асран хамгаалагч байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол харьяа нутаг дэвсгэрийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоон оролцуулах нөхцөл байдал бодитой үүссэн эсэхэд дүгнэлт хийж байх шаардлагатай.

6.3.Өмгөөлөгч оролцуулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэж заасан хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн хохирогч амьдралын нөхцөл боломж муу, төлбөрийн чадваргүйн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч авч өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах тохиолдол бага байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайлбал: 98 хохирогчийн 60 буюу 61.2 хувьд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцуулаагүй байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.2-т “Эрүүгийн хуулийн ...13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан тохиолдол”-д хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхээр заасан.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дугаар тушаалаар батлагдсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмаар хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан ба журмын 6 дугаар зүйлийн 6.1-д “Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.2-т заасан хохирогч хүүхдэд хүүхдийн асуудлаар мэргэшсэн, дагнасан улсын өмгөөлөгчөөр үзүүлэх боломжоор хангах” асуудлыг тусгасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль зүйн туслалцааны тухай хууль болон “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах, гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй үзүүлэх, 18 насанд хүрээгүй бол хүүхдийн асуудлаар мэргэшсэн, дагнасан улсын өмгөөлөгчөөр үнэ төлбөргүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

6.4.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох.

Судалгаанаас үзэхэд, гэмт хэргийн улмаас хохирсон 98 хохирогчийн 60.2 хувьд нь гэмтлийн зэрэг болон бэлгийн харьцаанд орсон ул мөр бий эсэхийг тогтоох, 39.8 хувьд нь сэтгэцийн байдалд шинжилгээ хийхээр шинжээч томилж дүгнэлт гаргуулсан байна.

Судалгааны дүнгээс харахад уг ажиллагаа хангалтгүй байгаа нь нэг талаас хохирогчийн зүгээс шинжээчид

үзүүлж дүгнэлт гаргуулахаар татгалздаг, эрх зүйн мэдлэг дутмаг, нөгөө талаар мөрдөгч, прокурор мөрдөн шалгах ажиллагааны явцад санал санаачлага гаргадаггүй, хохирогчид цаашид гарах үр дагавар, хуулийн зохицуулалтын талаар мэдээлэл өгдөггүйтэй холбоотой байх тул цаашид мөрдөгч, прокурор нь дээрх хуулийн зохицуулалтад нийцүүлэн холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулан, нотлох баримтуудыг цуглуулж, шинжээч томилон сэтгэцийн шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулж, хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгох, цаашилбал сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл заслын эмчилгээнд зарцуулах зардлыг тогтоосон нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагааны явцад заавал хийлгэж хэвших шаардлагатай байна.

2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Шүүх шинжилгээний тухай хуулийн 39.1 дүгээр зүйлд сэтгэцийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлагыг заасан ба энэ зүйлийн 39.1.8 дахь хэсэгт “сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ”-г тогтоох зорилгоор сэтгэцийн шинжилгээг хийлгэх, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг (Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг), Арван гуравдугаар бүлэг (Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг), 14.1 дүгээр зүйл (Ялгаварлан гадуурхах), Арван зургаадугаар бүлэг (Хүүхдийн эсрэг) зэрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож дүгнэлт гаргахаар, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт Шинжилгээний байгууллага сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахдаа харгалзан үзэх нөхцлүүдийг зааж, хүний сэтгэцэд

учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах талаар нарийвчлан хуульчилсан.

Шүүх шинжилгээний тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайд нарын 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”, “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”-ийг тус тус баталсан.

Тус журмаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах харилцааг зохицуулжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад, хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох ажиллагаанд ач холбогдол өгч, хууль, журамд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулж, нотлох баримтыг цуглуулан, хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, сэтгэцэт учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл заслын эмчилгээнд зарцуулах зардлыг нотлох баримтаар тогтоох ажиллагааг заавал хийж хэвших шаардлагатай.

6.5.Хохирол нөхөн төлүүлэх.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-15.3 дахь хэсэгт хохирогч өөрт учирсан эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо гэм буруутай этгээдээс шаардаж, нөхөн төлүүлэх эрхтэй талаар дурдаж, хохирлын хэмжээг шүүх тогтоохоор заажээ.

Судалгаагаар хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад болон прокурорын хяналтын шатанд энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг мөнгөн дүнгээр илэрхийлэн тогтоож, хохирогчид нөхөн төлүүлсэн тохиолдол гараагүй байна.

Харин шүүхийн шийдвэрээс үзэхэд, 10 хэргээс 5 хэргийн 6 шүүгдэгчээс нийт 3.989.068 төгрөгийг гаргуулж хохирогч нарт олгуулах, насанд хүрээгүй хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлсний төлбөрт 4.576.439 төгрөгийг гаргуулж, нэр бүхий төрийн бус байгууллагад олгуулахаар тус тус шийдвэрлэж, бусад 5 хэргийн шийдвэрт “иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй” гэж ерөнхий байдлаар дурдсан байна. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирол, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох ажиллагаа хангалтгүй, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирол, хор уршгийг мөрдөн шалгах ажиллагааны явцад мөнгөн илэрхийллээр тогтоон, нөхөн төлүүлэх арга хэмжээг авах, яллагдагчийн гэмт үйлдлийн замаар олсон эд хөрөнгө, түүнээс олсон ашиг, орлого, гэмт

хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгсэл, эд зүйлийг илрүүлэх, хураан авах, битүүмжлэх ажиллагааг шуурхай явуулах шаардлагатай ба уг ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу шүүхээс хохирол нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

6.6.Хохирогч хамгаалал.

Судалгаанд хамрагдсан хохирогчдын 81.8 хувьд нь хамгаалалтын арга хэмжээ аваагүй байна. Энэ нь мөрдөгч, прокурор холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулдаггүй, санал санаачилга гаргадаггүй, нөгөөтэйгүүр хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээдээс Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах, туслалцаа авах талаар хүсэлт, гомдол гаргаагүйтэй холбоотой байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно” гэж заасан.

Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл

халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандах хуулийн зохицуулалттай.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан сэтгэл зүйн болон аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хохирогч гэмт хэрэгт дахин өртөхөөс сэргийлэх, түүний нэр төр, эрх ашгийг хамгаалах болон гадны аливаа нөлөөллөөс хамгаалах, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор авна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж, хохирогчийг таньж тогтоох, түүний нэр төрийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хохирогч хүүхдийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заасан.

Иймд дээрх ажиллагаанд санаачилга гарган ажиллаж, хууль, журмыг нэг мөр хэрэгжүүлэн, тодорхой мөрдөн шалгах ажиллагааг явуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг авах хэрэгцээ шаардлага байгаад анхаарах.

6.7.Хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.3 дахь заалтад заасны дагуу Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2014 оны А/356, А/182 дугаартай хамтарсан тушаалаар “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”-ыг баталсан.

Журмын 2.1-т “Гэрч, хохирогч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг цагдаа, авлигатай тэмцэх, тагнуулын байгууллага бүрдүүлэх бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллага өмчийн хэлбэрээс үл хамааран гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ” гэж заасан.


Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд, хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн, сэтгэл зүйн, эрүүл мэнд, нийгмийн бусад туслалцааг үзүүлэхээр зааж, хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүй, сэтгэл зүйн туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхээр зохицуулсан байна.

Хуулинд нийгмийн бусад туслалцаа гэдэгт, хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлж байгаа тусламж үйлчилгээг ойлгохоор тодорхойлсон байна.

Судалгааны дүнгээс үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын 73-д нь тусламж үйлчилгээ

үзүүлээгүй ба тусламж үйлчилгээ авсан 26 хохирогчийн 18 буюу 69.2 хувьд нь хамгаалах байранд байрлуулах, 2 буюу 7.7 хувьд нь сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, 6 буюу 23.1 хувьд нь хууль зүйн туслалцаа үзүүлэх, тусгай хэрэгцээг хангах үйлчилгээг үзүүлсэн байна.

График 9.



Түүнчлэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар бүлэг буюу хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэрт хохирогч хамгаалал, тэдэнд туслалцаа үзүүлэхэд шаардлагатай журмыг батлан гаргах харилцааг зохицуулсан.

Үүний дагуу Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/462 дугаартай тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дугаартай тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 09-ни өдрийн А/135 дугаартай тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх тусламж,

үйлчилгээ үзүүлэх журам”, Хууль зүйн сайдын 2017 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/49 дугаартай тушаалаар “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам” (2020 оны А/96 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан) тус тус баталсан байх ба уг журмууд нь хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд хэрэгжиж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчид дээрх журмуудаар зохицуулагдсан тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлага байгаа эсэхийг шуурхай тодорхойлж, тэдний хэрэгцээ шаардлагад тохирсон тусламж, үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг авч, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг нэг мөр хангуулах.

6.8. Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах асуудал.

Монгол улсын эдийн засаг, нийгмийн бүхий л салбар, иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтэрч, интернэт, олон нийтийн цахим сүлжээний хэрэглээ өдөр тутмын ажил, амьдралын салшгүй нэг хэсэг болсон.

Иргэдийн олон нийтийн цахим сүлжээний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр кибер орчныг ашиглаж үйлдэх гэмт хэргийн тоо нэмэгдэх, тэр дундаа кибер орчин ашиглаж хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх таатай нөхцөл бүрдсэн гэж дүгнэж болохоор байна.

НҮБ-ын 2020 оны “Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын талаарх тайлан”-д “Хүн худалдаалах

гэмт хэргийг хөнгөвчлөхийн тулд гэмт этгээд интернэт технологийг ашиглаж байна” гэж,

Мөн Шүүхийн академиас хийсэн “Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгааны тайлан”-д “Олон улсын эрх зүйд хүн худалдаалах ойлголтыг уламжлалт байдлаар ойлгохоос гадна цахим хэрэгсэл ашиглан мөлжих ойлголтыг ч хамааруулж үзэж байна”² гэж тус тус дурдаж, цахимаар худалдаалах гэсэн ойлголтыг тодорхойлсон байна.

“Цахимаар худалдаалах” гэдэгт мөлжлөгийн зорилгоор хохирогчийн зөвшөөрлөөр, хүчээр, хууран мэхлэхийн тулд компьютерын систем, интернэт үйлчилгээ, хөдөлгөөнт төхөөрөмж, ухаалаг мэдээллийн самбар, цахим мэдээлэл хадгалах, дамжуулах үйлдэл бүхий төхөөрөмж ашиглан “хүн тээвэрлэх” явдал юм. Хүнийг тээвэрлэх /англ.*Transport in persons*/ гэж мөлжлөгийн зорилгоор хохирогчийн зөвшөөрсөн эсэхээс үл шалтгаалж элсүүлэх, сурталчлах, уруу татах, тээвэрлэх, худалдах, худалдан авах, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авахыг хэлнэ.²

НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас цахим сүлжээ, технологийн элемент агуулсан хүн худалдаалах гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн судалгаанд “Веб камер болон шууд дамжуулалт нь мөлжлөгийн шинэ хэлбэрийг бий болгож, хохирогчдыг тээвэрлэх, шилжүүлэх хэрэгцээг багасгаж байгаа...”³

² НҮБ-ын 2020 оны “Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын талаарх тайлан”

³ Шүүхийн академиас хийсэн “Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгааны тайлан”

Хүн худалдаалагчид хохирогчдын хүчирхийллийн дүрс бичлэгийг шууд дамжуулж давтамжтай мөлжиж байх бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудад тус гэмт хэрэгтэй тэмцэхэд улам бэрхшээлтэй болгож байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг элсүүлэх, эрхшээлдээ байлгах, мөлжих шинэ арга хэлбэрийг бий болгож эрүүгийн эрх зүйн орчныг хурдацтай өөрчилж байна. Онлайн платформоор хэрэгжиж буй орчин үеийн хүн худалдаалах гэмт хэргийн үйл явц нь хүн худалдаалагчдад хохирогчдыг заавал биечлэн уулзахгүйгээр элсүүлэх, хянах, ашиглах боломжийг олгодог”⁴ гэж дурдсан байна.

Түүнчлэн мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи нь гэмт этгээдийг кибер орчинд гэмт хэрэг үйлдэх таатай нөхцлийг бүрдүүлж байгаа бөгөөд гэмт этгээд кибер орчинд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглан, хохирогчтой харилцаа тогтоох, улмаар ажлын санал тавих, худал амлалт өгөх зэргээр итгэл төрүүлж, хувийн мэдээллийг нь авах, түүгээр нь дарамтлах эрхшээлдээ оруулах, элсүүлэх, цаашлаад ойр дотны хүн, найз нөхдийг элсүүлэх байдлаар гэмт хэргийг үйлдэж байна.

Кибер орчныг ашиглаж үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт хэргийн онцлог, нөхцөл байдлаас хамаарч ердийн гэмт хэргийн мөрдөн шалгах

⁴ V Greiman, C Bain, The Emergence of Cyber Activity as a Gateway to Human Trafficking, Journal of Information Warfare, Vol. 12, No. 2 (2013), 43. <https://www.jstor.org/stable/26486854?seq=88>)

ажиллагаанаас онцлог бөгөөд ялгаатай. Прокурор кибер өгөгдөл, нотлох баримттай ажиллах, бэхжүүлэх, шинжлэх, үнэлэх чиглэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгчийг чиглүүлэхийн тулд энэ чиглэлээр судалсан, зохих түвшний мэдлэг, чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Тухайлбал, кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцлог, мөрдөн шалгах ажиллагааны дараалал, үе шат, мэдээлэл хайх, цуглуулах эх сурвалж, арга хэлбэрийн талаар тодорхой мэдлэгтэй байх нь зүйтэй.

ДОЛОО. ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг-1. Хохирогчийн хүйс.

НАЙМ. ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График-1. Гомдол гаргагчийн төрөл.

График-2. Шалгагдсан гэмт хэргийн төрөл.

График-3. Шинээр бүртгэгдэн шалгагдсан хэргийг он тус бүрээр харьцуулсан харьцуулалт.

График-4. Хохирогчийн нас.

График-5. Хохирогчийн хохирсон гэмт хэргийн төрөл.

График-6. Эзлэх хувь

График-7. Шүүхэд шилжүүлсэн хэргийн шийдвэрлэлт.

График-8. Насанд хүрээгүй хохирогчид хууль ёсны төлөөлөгч оролцуулсан байдал.

График-9. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдал.

ЕС. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.

9.1.Хууль тогтоомж:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
- Шүүх шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/

9.2.Улсын дээд шүүхийн тогтоол

- Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар “Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” тогтоол.
- Улсын Дээд шүүхийн 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 65 дугаар тогтоол.

9.3. Олон улсын гэрээ, конвенц, протокол

- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол” /Палермогийн протокол/
- “Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол”

9.4. Холбогдох журам.

- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”,
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”,
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2014 оны А/356, А/182 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”,
- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/462 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”,

Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”,

- Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 09-ни өдрийн А/135 дугаар тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”,

- Хууль зүйн сайдын 2017 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/49 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам” (2020 оны А/96 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан)
- Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайдын 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”, “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”.

9.5. Судалгааны дүн

- УЕПГ-аас “Хүн худалдах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөл”-ийг 2022-2023 оны байдлаар судалсан судалгаа.

9.6. Бусад материал:

- *“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах гарын авлага”*
- *“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгааны тайлан,*
- *“Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгаа”-ны тайлан”*

- НҮБ-ын 2020 оны “Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын талаарх тайлан”,
- “Хүүхэд хамгаалал дахь төрийн оролцоо ба эрх зүйн зохицуулалт” хүүхдийн байгууллагын ажилтанд зориулсан гарын авлага.
- “Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа” сургалтын гарын авлага.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

[illegible]

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

